

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ  
НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН  
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 02 сарын 27

Мандалговь хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Дундговь аймгийн Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх, хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 -т заасан арга зүйгээр үнэлэн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим санд байршуулсан.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:**

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн 2 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 -т заасан аргачлалын дагуу хяналт- шинжилгээ, үнэлгээг хийхэд 100 хувьтай байна.

## Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Заалтын тоо	100	70	ХТХБ	Хувь
1.Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	11	11			100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	7	7			100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	2	2			100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	2	2			100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	1	1			100
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	2	2			100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	1	1			100
	Дүн	26	26			100

**АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,  
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ОНЦЛОХ  
АЖИЛ**

**1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх**

Дундговь аймгийн хэмжээнд 2021-2025 онд “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг санаачлан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж 2021 оноос хэрэгжүүлж эхлээд байна.


“Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд аймаг орон нутгийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай өндөр чадамж бүхий боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж 2020 оны байдлаар 64.9 хувтай байгаа боловсон хүчний хангалтыг 2025 онд 85 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Албан хаагчдыг мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр Засгийн газар болон төрийн байгууллагаас зохион байгуулсан 512 төрлийн сургалтад 1758 албан хаагчийг хамруулсан байна. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 хэлтэс агентлаг, 15 сумын төсвийн 134 байгууллагын 3462 төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх 302 удаагийн ажлын байрны сургалтад хамруулсан байна.






Аймгийн хэмжээний удирдах ажилтнуудын сургалт зөвлөгөөнд 15 сум, 23 агентлагийн 181 албан хаагч, аймгийн ЗДТГ-аас 30 албан хаагч, нийт 211 албан хаагч амжилттай оролцож мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.





Гадаад орны сайн туршлагыг орон нутагт нэвтрүүлэх, албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх санал, санаачилгыг дэмжин гадаад улс орнуудтай туршлага судлах ажлыг зохион байгуулж 2023 онд 16 гадаадын улс орнуудад салбар салбарын 86 төрийн албан хаагчийг туршлага судлах болон мэргэжил дээшлүүлж мэргэшүүлэх сургалтад хамруулж орон нутгийн төсөв “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрөөс 133.5 сая төгрөгийг зарцууллаа.






## 2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

Төрийн албан хаагчийг “Шилдэг төрийн албан хаагч”-аар өргөмжилж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус бүр 1.0 сая төгрөг, өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа.




Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 16 агентлагийн 206 төрийн захиргааны албан хаагчдад 158.7 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын 36 төрийн жинхэнэ албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 30-40 хувиар тооцон олгосон байна.



Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайруулж 9 сумын Засаг даргын тамгын газар, Тусгай чиг үүргийн 5 байгууллагад 53,4 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг хийсэн.



Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангаж буй байдалд сэтгэл ханамжийн судалгаа авахад 85,6 хувьтай байгаа нь өмнөх оноос 3,5 хувиар өссөн байна. Сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн албан хаагчдад 56 сая төгрөгөөр шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахаас гадна өрөөнүүдэд засвар хийж ажиллах орчныг нь бүрдүүлсэн.



**ТӨРИЙН АЛАН ХААГЧДЫН АЖИЛЛАЖ, АМЬДРАХ  
ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ**








- 1 •66 багийн Засаг даргад зөврийн компьютер, мотоцикл, 15 сум, 8 байгууллагад нэн шаардлагатай техник хэрэгсэл.
- 2 •Дэлгэрцогт, Цагаандэлгэр албан Дэлгэрхангай, суманд төрийн хаагчийн байр засварласан.
- 3 •7 төрийн албан хаагчид гэр, байр орон сууцны дэмжлэг.

ДУНДГОВЬ ХӨГЖИНӨ ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Мөн орон нутгийн төсвөөс 68 багийн Засаг даргад зөврийн компьютер, хөдөөгийн нэн шаардлагатай багуудад мотоцикл олголоо.



Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт 2102 төрийн албан хаагчийг хамруулж нийт төрийн албан хаагчийн 92.1 хувийг бүрэн хамруулсан байна.

Төрийн албанд ажиллаж байгаа эрүүл мэндийн тусламж дэмжлэг нэн шаардлагатай 10 төрийн албан хаагчдад “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрөөс 14.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор UB med эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний үндсэн дээр 5 төрлийн багц үзлэг, оношилгоо шинжилгээнд 67 албан хаагчид 100 хувь хамруулсан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт орон нутгийн төсвөөс 19,9 сая төгрөгийг зарцуулсан.



Эрүүлжүүлэх чиглэлээр 3-р шатлалын эмнэлэгт үзүүлэх шаардлагатай 3 төрийн албан хаагчдад 10 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн. Мөн албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 4.9 сая төгрөгийн дархлааны багцыг олголоо.



Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 15 төрийн албан хаагчид гэр, байр орон сууцны дэмжлэг 139,5 сая төгрөгийн олгов.



Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр 37 оюутантай гэрээ байгуулан боловсон хүчнийг бэлтгэж сургалтын төлбөрийн дэмжлэгт 42.2 сая төгрөг зарцуулсан.




Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг ханган ажиллахаар тус аймаг нь 2021 оноос “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд аймгийн ИТХ-аар тус хөтөлбөрт 750 сая төгрөгийг батлуулан төрийн албан хаагчдыг хөгжүүлэх сургалт, нийгмийн баталгаанд зарцуулаа.

Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр 350.0 сая төгрөгийг зарцуулсан байна.



Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал /Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрөөс сая төгрөг/



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 зорилт 7 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 100 хувийн гүйцэтгэлтэйгээр үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд

албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн.

“Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр 350.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймаг орон нутгийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай өндөр чадамж бүхий боловсон хүчнийг бэлтгэхэд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр 37 оюутантай гэрээ байгуулан боловсон хүчнийг бэлтгэж сургалтын төлбөрийн дэмжлэгт 42.2 сая төгрөг зарцуулсан.

Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 15 төрийн албан хаагчдад гэр, байр орон сууцны дэмжлэг 139,5 сая төгрөгийг зарцуулсан тодорхой үр дүнд хүрсэн үр нөлөөтэй ажлуудыг зохион байгуулсан байна.

“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд аймгийн ИТХ-аар тус хөтөлбөрт 750 сая төгрөгийг батлуулан төрийн албан хаагчдыг хөгжүүлэх сургалт, нийгмийн баталгаанд зарцуулж байгаа нь орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдын хангалт 83 хувьд хүрч нийгмийн баталгааны дэмжлэгт хамрагдаж буй албан хаагчдын тоо нэмэгдэж сэтгэл ханамж жилээс жилд нэмэгдсэн үр дүнгүүд гарч байна.

#### **ТАВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ**

Төрийн албан хаагчийн сургалт,ажиллах нөхцөл,нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг аймгийн захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж байх /Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс/

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.МЯГМАРМЯДАГ